Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор батлсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 4 дүгээр хавсралт

Хагас жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 2/ */Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 378 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/*	
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.	
Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдөр/	2026 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2026 оны 6 дугаар сарын 30-ны өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	МЕРЕКС ХК Регистрийн дугаар: 5631084 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 9010001122 Үнэт цаасны код: MRX Утасны дугаар: 7777-2247
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Барилгын салбар
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	65,005,000 ширхэг
Хагас жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр */Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 378 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/*	Бэлтгэсэн: Д.Доржпалам, ерөнхий нягтлан бодогч Хянасан: МЕРЕКС ХК-ийн ТУЗ-ийн дарга Г.Бямбабаяр

1.	*Хагас жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/* */Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 378 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/*	
	Санхүүгийн байдлын үзүүлэлт	Нийт хөрөнгө: 16,635,115,853.70 (оны эхэнд 16,868,216,945.70) Эргэлтийн хөрөнгө: 15,067,386,498.43; эргэлтийн бус хөрөнгө: 1,567,729,355.27 Богино хугацаат өр төлбөр: 12,875,672,790.31; урт хугацаат өр төлбөр: 0 Эздийн өмч: 3,759,443,063.39
	Орлогын тайлан	Борлуулалтын орлого: 807,324,727.2
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	6,500,500,000.
	Мөнгөн гүйлгээний тайлан	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ: 21,041,507.50 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ: -349,000.00 Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ: 0.00 Бүх цэвэр мөнгөн гүйлгээ: 20,692,507.50 Мөнгөний эхний үлдэгдэл: 5,007,747.01; эцсийн үлдэгдэл: 25,700,254.51
2.	*Хагас жилийн санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт* */Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 378 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/*	
	Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо МЕРЕКС ХК-ийн 2026 оны 1 дүгээр сарын 01-ээс 6 дугаар сарын 30-ны хоорондох хагас жилийн санхүүгийн тайланг (санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан) хэлэлцэж дараах дүгнэлтийг гаргав. 1. Санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэсэн бөгөөд захирал, ерөнхий нягтлан бодогч нар тайлангийн үнэн зөв, бүрэн байдлыг баталгаажуулсан байна. 2. Тайлант хугацаанд нийт хөрөнгө 16,635,115,853.70 төгрөг, өр төлбөр 12,875,672,790.31 төгрөг, эздийн өмч 3,759,443,063.39 төгрөг байна. Борлуулалтын орлого 807,324,727.28 төгрөг, нийт ашиг 174,909,063.22 төгрөг, цэвэр ашиг 2,053,883.17 төгрөг болсон. Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ 21,041,507.50 төгрөг, мөнгөний эцсийн үлдэгдэл 25,700,254.51 төгрөг байна. 3. Хорооны анхаарвал зохих асуудлууд: (а) хуримтлагдсан алдагдал 2,741,056,936.61 төгрөг хэвээр байна; (б) нийт өр төлбөр нь нийт хөрөнгийн 77.4%-ийг эзэлж, бүгд богино хугацаат; (в) мөнгөний харьцаа 0.002 буюу мөнгөн хөрөнгө бага; (г) дансны авлага 9,204,591,847.94 төгрөг хөдөлгөөнгүй байна; (д) тайлант үеийн ерөнхий ба удирдлагын зардал тусгагдаагүй. Эдгээрийн талаар удирдлагаас тайлбар авч, авах арга хэмжээг тодорхойлно.	
3.	*Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт*	
3.1.	*Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/*	Нийт ашгийн хувь: 21.7% (өмнөх үе 57.2%) Цэвэр ашгийн хувь: 0.25% (өмнөх үе 0.02%) Борлуулалт, маркетингийн зардал / орлого: 21.4% Хөрөнгийн өгөөж (ROA, тайлант үеийн): 0.012% Эздийн өмчийн өгөөж (ROE, тайлант үеийн): 0.055%

		Борлуулалтын орлого: 807,324,727.28 (өмнөх үе 1,695,810,888.89)
3.2.	*Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт*	Одоогийн харьцаа: 1.17 (оны эхэнд 1.17) Хурдан харьцаа (бараа материалгүй): 1.15 Хатуу харьцаа (бараа материал, урьдчилж төлсөн зардалгүй): 0.91 Мөнгөний харьцаа: 0.002 Цэвэр эргэлтийн хөрөнгө: 2,191,713,708.12 Нийт өр төлбөр / нийт хөрөнгө: 77.4%; өр төлбөр / эздийн өмч: 3.42 дахин Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө: 25,700,254.51 (оны эхэнд 5,007,747.01)

3.3.	*Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл*	Түлш, шатахууны хомсдол, үнийн тогтворгүй байдал нь үйл ажиллагаа явуулахад саад учруулж байна. Компаниас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ: түлшийг урьдчилан нөөцлөх, нөөцийн түлшний савын хэмжээг томруулсан.
3.4.	*Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого*	Санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв тусгасан. Тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээ байхгүй. Нягтлан бодох бүртгэлийн бодлого: хууль болон бүртгэлийн стандартыг баримтлан ажиллана.
4.	*Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/*	
	Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй хэлцэл байхгүй.	
5.	*Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл*	
	Олон нийтэд санал болгон хувьцаа гаргаж төсөл хэрэгжүүлээгүй.	
5.	*Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл*	
	1. Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ): хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шинээр сонгогдсон 9 гишүүнтэй, үүнээс 3 нь хараат бус гишүүн (А.Билгүүн, Г.Чинхүсэл, Г.Ганхүлэг). ТУЗ-ийн дарга Г.Бямбабаяр. Гишүүд: М.Ундрал, Э.Эрдэнэсүх, Л.Чулуунбаатар, Г.Ганхүлэг, А.Санчир, А.Билгүүн, Г.Чинхүсэл, Б.Цэрэнханд. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Д.Уянга. Шинээр гишүүнээр Г.Ганхүлэг орсон. 2. ТУЗ-ийн хурал: 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр ТУЗ-ийн ээлжит хурал хуралдаж, 9 гишүүнээс 9 нь оролцсон (ирц 100%). Хурлаар ТУЗ-ийн дарга, нарийн бичгийн даргыг сонгох, ТУЗ-ийн дэргэдэх хороодыг байгуулах, гүйцэтгэх захирлын асуудлыг санал нэгтэйгээр шийдвэрлэсэн. ТУЗ-ийн хурлыг жилд 5 удаа хуралдуулахаар төлөвлөж, 2026 оны ТУЗ-ийн гишүүдийн цалинд 23,600,000 төгрөгийн төсөв батлсан. 3. ТУЗ-ийн дэргэдэх хороод: Нэр дэвшүүлэх хороо — А.Санчир (дарга), М.Ундрал, Б.Цэрэнханд. Аудитын хороо — Б.Цэрэнханд (дарга), А.Билгүүн, Г.Чинхүсэл. Шагнал урамшууллын хороо — А.Санчир, Э.Эрдэнэсүх, Л.Чулуунбаатар. 5. Гүйцэтгэх удирдлага: гүйцэтгэх захирал Г.Чинхүслэн. 6. Хувьцаа эзэмшил: ТУЗ-ийн дарга Г.Бямбабаяр 27,601,289 ширхэг (42.5%), ТУЗ-ийн гишүүн М.Ундрал 7,801,000 ширхэг (12.0%) хувьцаа эзэмшинэ.	
6.	*Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл*	
	ТУЗ-ийн 2026.04.17-ны өдрийн хурлын шийдвэр, тэмдэглэл, тогтоолууд. Мэдээллийг олон нийтэд ил тод болгосон байдал: Хөрөнгийн биржийн сайт болон брокерын компаниудаар нээлтэй байгаа болно.	
Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:		

Овог, нэр: Г.Чинхүслэн Албан тушаал: Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:

Огноо: 2026 оны 07 дугаар сарын 20 өдөр

МЕРЕКС ХК MEREX JSC УЛААНБААТАР ХОТ ТТС5479 5631084

(Тамга, тэмдэг)

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 378 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

МЕРЕКС ХК MEREX JSC УЛААНБААТАР ХОТ ТТС5479 5631084

Овог, нэр: Д.Доржпалам

Албан тушаал: Ерөнхий нягтлан бодогч Гарын үсэг: